



**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/12

Эрдэнэт

Улаанбаатар-2022 чөлөөт бөхийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотод 2022 оны 01 дүгээр сарын 12-14-ны өдрүүдэд зохиогдсон Улаанбаатар-2022 чөлөөт бөхийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд Орхон аймгаас оролцсон 14 хүний байр, хоолны зардалд 720,000 (долоон зуун хорин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх тэмцээний зардал 720,000 (долоон зуун хорин мянга) төгрөгийг зохих журмын дагуу уралдаан, тэмцээний зардалаас гаргаж, “Монголын Чөлөөт бөхийн холбооны НҮТББ” Орхон аймаг дахь салбар холбооны дансанд шилжүүлэхийг нягтлан бодогч (Б.Мөнхцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Д. ДЭЛГЭРБАЯР
